



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ХАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЭГЧ АГЕНТАГ  
СОЁЛ, УРЛАГИАЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН НӨРСӨН  
НӨМЬН САН  
МОНГОЛ УЛСЫН НӨРСӨН  
НӨМЬН САН

“Үндэсний бичиг үсгийн баяр-2019”-ын хүрээнд зохион байгуулах

# “ДААВУУН АРТАЙ СОЁЛЫН БАРИМТАТ ӨВИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ”



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ОНОЛ ПРАКТИКИЙН ХУРЛЫН  
УРИЛГА, ХӨТӨЛБӨР

Улаанбаатар  
2019.05.06

## ХӨТӨЛБӨР

### 9:30-10:00 НЭЭЛТИЙН АЖИЛАГАА

- *Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Соёл урлагийн газрын дарга Г. Эрдэнэбат*
- *ЮНЕСКО Монголын Үндэсний Комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга С. Утга*

**Хурлын дарга:** Д. Мэндсайхан /ЗГХА, Соёл урлагийн газрын мэргэжилтэн, соёл судлаач, доктор Ph./

Б.Тунгалаг /МУҮНС, Сан хөмрөг хадгаламжийн хэлтсийн дарга соёл судлаач, доктор Ph./

10:10-10:25 *Дэлхийд хосгүй Монгол угийн бичиг*

Б. Сумъяабаатар /Чингис хаан судлалын хүрээлэнгийн захирал, доктор. Sc., профессор/

10:25-10:40 *Даавуун дээр зурсан Монгол нутгийн зурагуд*

Ж. Гэрэлбадрах /МУБИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч, доктор Ph., профессор/

10:40-10:55 *МУҮНС-д хадгалагдаж буй даавуун артай хх сурвалжууд*

Ч. Гансүх /МУҮНС-ийн Сан хөмрөг хадгаламжийн хэлтэс, Монгол судлал гар бичмэл номын сан хөмрөгийн номын сангч/

10:55-11:10 *Даавуун артай баримтат овийг тооцон хэлбэрт оруулж байгаа оноогийн байдал*

П. Гийхнаран /МУҮНС-ийн Мэдээлэл аргазүй, эрдэм шинжилгээний хэлтэс, Цахим ном бүрдүүлэгч/

11:10-11:25 *Шинээр олдсон нэгэн дархан тэмдэгт бичиг*

Ч. Батдорж /ШУА-ийн Түүх археологийн хүрээлэнгийн ЭША/

11:25-11:40 *Гарчиг болоод донторын хамаарал*

Х. Түмэнбаяр /МУҮНС-ийн Мэдээлэл аргазүй, Эрдэм шинжилгээний хэлтэс, Бүртгэл мэдээллийн сангч/

11:40-11:55 *Монгол зураг баримтат ов болох нь*

Ш. Энхтуяа /Соёлын овийн Үндэсний тов Ерөнхий бүртгэл мэдээллийн сангч/

## Дэлхийд хосгүй монгол Угийн бичиг

Б.Сумьяабаатар(Монгол. IUU.Чингис Хаан судлалын хүрээлэн)

01. Угийн бичгийн учир

02. Сэцэн Хан Шолойн Угийн бичиг

03. Угийн бичиг бичих тусгай төхөөрөмж

### 01. Угийн бичгийн учир

Монгол бол дорно, өрнийн өтгөс соёлын зангилаа орон. Тэр аугаа их соёлоос өвөг дээдэс маань “бидний юм” хэмээн өлгийдөж авсан, өвлөж уламжилсан, монгол түмнийг өдий болтол харьд уусгахгүй дархалж авчирсан **Их Оршил** бол **Угийн бичиг** ба **Гэрийн үеийн бичмэл** маань юм.

Монголчууд бид буурал эртний эрдэмт түмэн болохыг өв их соёл нь, өрх гэрийн бичмэл түүх нь бэлхнээ гэрчилнэ. Монголчуудын Угийн бичиг бол Нууц Товчооноос өмнө байсан дурсгал. “Узуурын бичиг” гэсэн нэртэй байсан. Угийн бичиг бол олон мянган хүний жирийн нэг хэлхээс биш. Бодгаль хүмүүсийн нэрээр бичсэн үнэн түүх, түүх бичлэгийн эртний арга. Сүүл үеийн дорнодахины албан түүхүүдэд “Олон шастир” нэрээр уламжилсан.

**Угийн бичигт монголчуудын сүнс сүлдэр, бурхан ухаан шингэсэн байдаг.**

Тийм ч учраас, 1920 –иод оны үеэс харийнхан, монголчуудын угийг мартуулах үүднээс юуны өмнө Угийн бичгээс нь холдуулах санаа өвөрлөн, элдвээр гоочилж, эцэст ‘зарлигдан’ хориглох, хүч хэрэглэглэх замд орж, тайж ястан, төрлийн дарга, бичиг номын мэргэд настангуудыг нь баривчилж хөнөөсөн.

Монголчуудын Угийн бичгийг хар сүүдэр дайрсан жилүүд байлаа.

Хөөрхийлөлтэй зарим нь түр цагийн бэрхийг даалгүй, тайж гарлын эцгийн нэрээ сольж, хиймэл ‘ард’ гаралтай болж ч хөглөсөн. Тэр нь илрээд ажил албанаасаа буусан хүмүүс ч бий.

Гэвч Угийн бичгийг нь монголчуудын өр зүрхнээс салгаж чадаагүй.

Монгол хүн ухаан зарж, номын сан, архивдаа хадгалуулж, үр ач нартаа цээжлүүлж, эмэгтэйчүүд нүгэл гэж бодсон ч суудалдаа далдлах зэргээр цөвүүн цагийг давж ирлээ.

Одоо, оюут хүний тархи ивэлж, ухаан ундарч, билигийн нүдэн нээгдэх сайхан цагтай золголоо, бид. Эрлийзүүдэд эрлэг нь, эн Их Монголдоо шүтээн нь болсон **Чингис Хааныхаа алтан ургийн Угийн бичгийг Монголчуудын Бахархлын бичиг** болгон тунхаглах цаг нэгэнт болжээ. Тийм Тунхаг бичиг бол, нийт монгол түмэндээ “**Чингис Хаан Одон**” хүртээсэнтэй тэнцэх сайн үйл болно. **Угийн бичиггүй Монгол бол шүншиггүй бурхантай** адил гэж санаж явдаг монгол түмний олон жил хүлээж буй Тунхаг бичиг дээ.

Чингисийн алтан ургийн Угийн бичгийн учир холбогдол буюу яагаад бид Угийн бичгээ шүтэж түүгээрээ бахархах ёстой юм бэ гэвэл:

- Чингисийн алтан ургийн Угийн бичиг бол монгол түмний хувь заяаг өвөрлөж, монгол түмэн юүгээ **бусдад уусгахгүйгээр** бидний үед авчирсан Ачлалт ном учраас юм.
- Есөн эрдэнээр номоо бүтээгсдийн удам – монгол туургатан бидний оюуны соёлын хосгүй дурсгал. Орой бүр эр эм хөгшин залуугүй баринтагт судраа магнайлан өргөж гэр хороогоо гороолон тойрч, эрдэм арвижихыг

бэлгэдэж заншигсдын удам – монгол туургатан биднээс хүн төрөлхитний далай арвин соёлын санд оруулсан үлэмж их хандив учраас юм.




- Хальт харахад тайж нарын үе залгамийн энгийн нэгэн бичиг мэт боловч, **хүн төвт түүхэн сурвалж** учраас юм.
- Цус ойртож, бие бөлгөн, ухаан мунхаг, удамшлын өвчинт үр ач нартай болохоос урьдчилан сэргийлэх далд увидастай, **монголчуудын эрүүл саруулын манаа, эсэн мэндийн баталгаа**, нөхөн үржихүйн эмийн судар учраас юм. Монголчуудыг өвчин эмгэгт баригдсан, өгөлж мөхөж буй үндэстэн гэж цээжний бангаар бичигсэд байсаан. Гэтэл, угийн бичигт маань арвангурав бол энүүхэнд, арван долоо найман эрэгтэй хүүхэдтэй хүн хүртэл тэмдэглэгдсэн. Эмэгтэй хүүхэд бас байсан байж л таараа. Энэ бол мэдрэмхийрэгчдийн нүүрийг улайлгах, нүглийг илчлэх баримт даруй мөн.
- Монгол айл бүрийн хэн ч **халдашгүй шүтээн хөрөнгө**, одооны хэллэгээр өрх бүрийн, хүн бүрийн үл хөдлөх хөрөнгө нь Гэрийн үеийн бичмэл учраас юм.
- Чингисийн алтан ургийн Угийн бичиг нь, **Монгол хэмээх улсын улстөр, төрийн хар хайрцагны бодлогын үндсийг агуулсан амин сүнс** учраас юм. Нэг үгээр хэлэхэд, Угийн бичиг нь монголчуудын тусгаар тогтнолын тунхаг бичиг. Өвөг дээдэс маань үе залгамжаа хольцоогүй, төрийнхөө алтан жолоог цэвэр ариун байлгах хэмээсэн эртний уламжлалт сонгомол нарийн аргыг бодож олсон нь Угийн бичиг юм. Түүнийг чанадлан барьж үе залгамжилж, засаг төрийн эрхийг барьдаг байсан тул **төрийн тэргүүнд харийн хүн шургалах** зүүн сүвэгчин төдий ч хий зай гаргахгүй, тийм **боломж олгодоггүй** байв.




















Өнөө цагт Чингис Хааныг маань нааш цааш нь чангаагсад үзэгдэх болов. Түүнд хөндөлдөх, түүнийг мухарлах, тэднийг дуугүй болгох цорын ганцхан зүйл бий, бидэнд. Тэр нь Чингисийн алтан ургийн Угийн бичиг ээ. Тэдэнд “За тэгвэл, Чингис Хаанаас удамтай хань(漢) үндэстнийхээ Угийн бичгийг гаргаад ирдээ, Чингис Хаанаас удамтай казах үндэстнийхээ Угийн бичгийг гаргаад ирдээ” гэдэг ганц өгүүлбэр л хангалттай. Тэдэнд тийм зүйл байхгүй.

Харин манайд бол хэдэн мянгаараа байна. Үндэсний номын санд гэхэд л 400 орчим бий. Үндэсний архив, хувийн цуглуулгад олон зуугаараа, мөн монгол хүн бүрийн өр зүрхэнд нь хадаастай, цээжинд нь шингээстэй байгаа. Угийн бичиг бол, хөх толбот монголчууд бидний зүрхний толт(ᠲᠤᠯᠤᠳᠤ toлта), амь амьсгаа, гал голомтын алтан багана аа. Үүнгүй(ᠡᠭᠦᠨᠦᠭᠡᠢ egün ügei) байсан бол аль хэдийн агаарт замхарчихсан байхыг үгүй гэх газаргүй. Тийм нандин, чухаг зүйлийн эзэн нь монгол туургатан бид нар. Угийн бичиг нь агуулга, хэмжээ, багаж төхөөрөмж, хийц маягаараа ч ертөнцийн чихийг дэлдийлгэж, нүдийг бүлтийлгэх бүтээл.

Жишээ нь, даавуу ар<sup>1</sup> тай буюу даавуун дээр бийрээр бичсэн, ЮНЕСКО-гийн соёлын өв, Гиннесийн номд бүртгүүлэх зиндааны бөгөөд, сүмогийн дэвжээ(4,55м)нээс том, дэлхийд хосгүй ховор Угийн бичиг гэхэд

л манай улсад гурван ширхэг байгаа.

Ийм зүйл байдаг гэдгийг сонссон, барааг нь харсан, зах сэжүүрээс нь барьж үзэгсэд олон боловч агуулгад нэвтрэгсэд, цөлбөн ( ödlekü) судлагсад цөөвтөр болов уу даа(нэрсийг тоолсон бололтой, үе үе тосон балын зурам байна лээ). Одоо хоёр нь Үндэсний Номын санд, нэг нь Үндэсний Архивын Газарт байгаа. Дээрхэндээ бүгд Номын санд байсан бололтой. Номын санд буй Угийн бичгийн ар дээр  (üledekü eki, үлдэх эх) гэж муугуу цааснаа бичээд наасан баримт байна ⇒  Тэгэхээр, номын санд хэд хэдэн хувь байснаасаа өөр газар шилжүүлсэн гэсэн үг.

- 1 Шинэ үсгээр “ар” гэж нэг хэлбэртэй бичдэг үгийг монгол худам үсгээр  aru ·  ar гэж хоёр янз бичнэ. Энэ нь цаанаа нарийн утга ялгадаг учраас юм. Эхнийх нь “ар, өвөр”ийн “ар”. Удаахь нь “ дэвсгэр  ” гэдэг үгтэй утга ойролцоо. Монгол хэлнээ “ар”, “булгаарин ар”, “жүн ар”, “тогосхон ар”, “торгон ар”, “төгрөгт ар”, “үүлт ар”, “цэцэг ар”, “шаа ар”, “ялин ар”; “багашиг ар”, “бяцхан ар”, “их ар”; “хуучин ар”, “шинэ ар”; “артай”, “ар бүхүй”; “аргүй”; “ар болгох”, “ар гаргах”, “ар хийх”; “ар дэвсгэр” гэх зэргээр хэрэглэл( kereglei 3116=хэрэгцээ) маш их, үүнд:
- “ар” ⇒ “булигаарин ар”, Гурван төгрөгт( togurigt) торго – торгонд *гурван төгрөгт арыг* анги ангиар хөндлөн жагсаан нэхснийг(Гучинзургааг тайлбар толь 11890.G-23-14b. T-3160), шинэ *артай* торго – хуучин *торгоны араас* өөр шинэ дүрэм авч нэхснийг (11891.G-23-14b. T-3160), үүлт торго – *арыг* үүлний адил хийн нэхсэн торгыг хэлнэ (11898.G-23-15a. T-3163), бүдүүлэг торго – чуурай ( ciyugai) торгоноос баахан бүдүүлэг бөгөөд *арыг* анги ангиар хөндлөн жагсаан нэхсэнийг нь (11901.G-23-15b. T-3163); их торгомсог –эсэн торгомсогоос баахан бүдүүлэг бөгөөд *ар* бүдэгхэнийг нь (11920.G-23-17b. T-3168); сиймхий торго, шаа – дэвсгэрийг сийрэгхэн, *арыг* нүдтэй болгон нэхсэнийг нь (11935.G-23-19a. T-3172).
- “артай” ⇒ “артай цаас”, “Дард~ Динбун   ” – алт утас оруулан нэхсэн цэцэг *артай* торгыг (11866. G-12a-11b. T-3154), шинэ *артай* торго – хуучин торгоны араас өөр шинэ дүрэм авч нэхснийг(11891.G-23-14b. T-3160); *жүн*( jung) *артай* торго–торгонд журам журмаар тогосхон ар хийн нэхсэнийг нь (11894. G-23-15a. T-3160); жүн( jung) артай торгомсог – журам журмаар *тогосхоныг ар хийн* утсанаар нэхсэн торгомсогийг (11911. G-23-16 b. T-3165), *артай* дурдам –ар бүхүй дурдамыг (11915.G-23-17a. T-3166), *артай* фанс – ар бүхүй фансыг хэлнэ (11925.G-23-18a. T-3169).
- “аргүй” ⇒ Ис( isü) – *аргүй* бараан торгыг хэлнэ (11887.G-23-14a. T-3159). “Гингин ( ginggin)–торгоны нэр. Бэдэрьяагийн өнгө, *аргүйг* нь хэлнэ(11888.G-23-14a. T-3159), шоо( sho) – ширхэгт хивийн адил, *аргүйг* нь(11929.G-23-18 b. T-3170).
- “ар болгох” ⇒ нолом – торгоны дэвсгэрт алтан утсыг *ялин*( yaling) *ар болгож* нэхснийг (11872.G-23-12b.T-3155); хэмэрлиг -зүйл бүр өнгийн ёнхороор *багашиг ар болгож* нэхснийг (11881.G-23-13b. T-3157); дурдам шаа – дурдмын адил бөгөөд шаагийн *ар болгон* нэхсэнийг нь (11944.G-23-19b. T-3174); гадар зотон – балын лавыг цагаан зотонд *ар болгож* дарж хөхчиний усанд будсаныг нь (11961.G-23-21a. T-3178).
- “ар гаргах” ⇒ *ар гаргаж* будах.
- “ар хийх” ⇒ Нол босоо магнаг – алтан утсаар луу таван зүйлийн өнгийн утсыг дэвсгэр гаргах-гүй үүл *ар хийж* нэхснийг (11859.G-23-11b. T-3152); Ундустан торго – улаан торгонд алтан утсаар *ар хийн* нэхснийг (11875.G-23-13a. T-3156); хожгор өөдөн( ogedeng) – өөдөн *ар хийн* нэхснийг (11877.G-23-13a. T-3156); жүн( jung) артай торго – торгонд журам журмаар *тогосхон ар хийн* нэхсэнийг нь(11894.G-23-15a. T-3160); торгомсог, чүсээ ( cuse) –ширхэгт хивээс, хээ торгоноос бүдэг, зүйл бүр *ар хийн* нэхсэнийг нь(11904. G-23-16a. T-3164); жүн ( jung) артай торгомсог – журам журмаар *тогосхоныг ар хийн* утсанаар нэхсэн торгомсогийг (11911.G-23-16 b. T-3165); чийрга( cigiray) торгомсог –

дэвсэх чийрс адил *ар хийн* нэхсэнийг нь(11918.G-23-17b. T-3167); дармал бөс – бөсөд зүйл бүр өнгийн *ар хийн* дарсныг нь(11973.G-23-22a. T-3181).


“*их ар хийх*” ⇒ артай дард – дардад *их ар хийж* нэхснийг(11859.G-23-12a. T-3154);

“*бяцхан ар хийх*” ⇒ бага таж – бага *бяцхан ар хийж* нэхснийг(11871.G-23-12 b. T-3155).




“*ар бүхүй*” ⇒ *ар бүхүй* дурдамыг артай дурдам хэмээмүй (11915.G-23-17a. T-3166); артай фанс – *ар бүхүй* фансыг (11925.G-23-18a. T-3169).

“*ар дэвсгэр*” ⇒ таж – *ар дэвсгэрийг* хоёр өнгийн ёнхроор ялгаруулан нэхснийг (11870.G-23-12b. T-3155) гэх мэт дэлгэр нэртөмьёо буй.



## 02. Сэцэн Хан Шолойн Угийн бичиг

*Аймаг:* Халхын Сэцэн Хан аймаг  Qalq-a-yin Sečen



қан аймаг Халхын Сэцэн Хан аймгийн *хил хязгаар нь*, дорно этгээд Эрдэнэ уулаар Хармөрөн мужийн Хөлөнбуйртай; Өмнө этгээд Тарган Чандмань(Цайдам), Бага элсэн манхан, Өвөр монголын Шилийн голын чуулганы хуучид, авга, авга нар хошуутай; Баруун этгээд цагаан чулуут; умар этгээд Орос улсын Байгалын сав газар,зүүн Шибэртэй; Зүүн өмнөд Шилийн голын чуулганы үзэмчин хошуутай, баруун урдуураа Халхын Түшээт Хан аймагтай тус тус зах нийлж байв. Халхын Сэцэн Хан аймагт өнөөгийн Хэнтэй, Сүхбаатар, Дорнод аймгийн нутаг, Дорноговь, Дундговь, Төв аймгуудын нутгийн зарим хэсэг багтаж байв. Сэцэн Хан аймагт Егүзэр хутагт, Ялгуулсан хутагт хэмээх шавь захирсан тамгатай хутагт байсан. Сэцэн Хан аймгийн сүүлчийн хан нь Навааннэрин байв.

⌘ *Бичмэлийн нэр:* [ Norburingc'in ий харалдаагаас эхлэн]  

(Sečen qan ayımaγ-un qan wang beyile beyise güng jasay olan tayı ji narun gerün üy-e-yin bičimel Сэцэн Хан аймгийн хан, ван,бэйл, бэйс, гүн, засаг, олон тайж нарын Гэрийн үеийн бичмэл) гэж хар бэхээр нэгэн мөрнөө бичсэн байна.

⌘ *Бичсэн он:* [ Donoi, Namil нарын харалдаагаас эхлэн] 

tabuduyar on. Namuγun segül sar-a-yin qorin qoyar .Олноо Өргөгдсөний тавдугаар он. Намрын сүүл сарын хорин хоёр) гэж хар бэхээр нэгэн мөрнөө бичсэн.

⌘ *Овог нэр:* Бөрт Чоноос 41-р үеийн Сэцэн хан Шолойгоор эхэлж, 54-р үеийн  (Lubsangyongcuy),  (Dor jürübü) хүртэл хөтлөсөн.

⌘ *Суурин:* Сэцэн хан Шолой (1-41-979)


⌘ *Үе:* 14

⌘ *Хүний тоо:* 12659





⌘ *Хэмжээ:* ~1884см \* 600см

⌘ *Хаана хадгалагдаж байгаа:* Монгол улсын Үндэсний номын санд. Дансны дугаар 7994/96. Бас ардаа 6484 гэсэн дугаар бий.





⌘ *Хэзээнээс, хэрхэн судласан:* Миний бие 1964, 1985.12.20-оос 1986 оны 11 сарын 03-ны даваа гараг болтол монгол худам үсгээр 8-р үеийг нь хүртэл 3673 хүний нэрийг хуулан авснаа 2000 оны 03 сарын 30-ны 20 цаг 30 минутаас 04 сарын 15-нд ром үсгээр галиглан оюутад шингээсэн ба 2018 оны гурван сараас 06 сарын 03-ны ням гарагийн 10<sup>55</sup>-д үлэх хэсгийг хуулан авч, 2018 оны 07 сарын 14-ний бямба гарагийн 15<sup>38</sup>-д бүгд нэрийн хэлхээг үйлдэн оюутлаж хэвлэлд бэлдэв.





⌘  (Олноо Өргөгдсөний тавду)ыг тааралдуулан **тамга** дарсан.



Тамганы үг нь:  Qan Kentei Ayulan-u Хан Хэнтэй Уулань (уулын)

 Сүүдэр,  Сүүдэр,  Сүүдэр,  Сүүдэр. Сүүдэр-у даруу-а-уин тамга-а Чуулганы даргын тамга.

⌘ Уул Угийн бичгийн ерөнхий байдлыг үлгэрлэн үзүүлбэл :

    Төвийн дугуйд, тухайлбал, тоононд нь “Сэцэн хан Шолой”

   гэж бичсэн. Халз дор нь тэргүүлсэн хөвүүнийг оноож бичсэн. Нэрсийг дээрээс доош, хүүхдүүдийг зүүн гараас баруун гар тийш тойруулан бичсэн. Ахмад хөвүүн нь зүүн  гартаа гэсэн үг. Бинтийг хул шар бэхээр тавьж, хүний нэрсийг хар бэхээр бичсэн байна.

- ⌘ Уул Угийн бичгийн нэг нь бороонд норж, зарим хэсэг нь урагдаж өмөрч ойчсон байх тул 5852 зэрэг гэрийн үеийн бичмэлийг ашиглан, өмөрч алга болсон хэсгийг нөхөж болно. Гэрийн үеийн бичмэлүүдийг латин галигаар буулгаж давхар ажил удах нь, нэгдүгээрт, дэлхий нийтээр манай гэрийн үеийн бичмэлүүдийг үзэж сонирхоход хэрэгтэй. Хоёрдугаарт, гэрийн үеийн бичмэлүүдийг байгаа эхээр нь буюу монгол худам үсгээр оюуглаж (*компьютерлэж*) болох боловч, монгол худам үсгээрхи хүний нэрсийг компьютерээр цагаан толгойн дэсэд оруулах түвшинд хараахан хүрээдүй байгаатай холбоотой. Техникийн дэвшлийн түвшин шинжлэх ухаанд ийм их ач холбогдолтой аж. Хүний нэрийн бүгд хэлхээгүй бол хэрэгцээт нэрээ хайж олж чадахгүй тул ямар ч ашиггүй. Иймийн учир, арга буюу латин галигт оруулж, монгол үсгээр давхар хадаж, толгойлох нүсэр ажил хийх болдог.
- ⌘ Уул гэрийн үеийн бичмэл нь Шолойгоор эхэлнэ. Шолой нь Бөрт Чоноос 41-р үеийн хүн бөгөөд 40-р үеийн Mooru Boyima (1-40-864), 39-р үеийн Amin Dural (1-39-786), 38-р үеийн Gersengje (1-38-749) ээр дамжин 37-р үеийн Батмөнх даян ханд (1-37-12) залгана.
- ⌘ Эцэг, хөвүүн хоёрыг... дүгээр хөвүүн гээд ард нь бинт тавьж, цол, хэргэм, зэргэ, тушаалыг дурдаж, дахин бинт тавьж нэрийг бичиж холбосон байна.
- ⌘ Шолойн ахмад хөвүүнийг зарим гэрийн үеийн бичмэлд Mećiri ilding tüsiyetü (seć1-42-1) гэсэн байх ба энд Mićiri гэж бичсэн нь тод харагдаж байна.
- ⌘ Mećiri – ийн ахмад хөвүүнийг зарим гэрийн үеийн бичмэлд “Radna, Радна” гэсэн байх ба энд харин Arana гэж бичсэн нь тод харагдаж байна. Мөн хоёрдугаар хөвүүнийг нь Ćabari, Ćeberi, заримдаа Ćaburi Erdeni, Ćebüri Erdeni заримдаа цуг бичсэн ч байдаг. Тэр бүгдийг засч нэг мөр болгоогүй. Байгаа чигээр нь хуулж, тайлбарлан толилуулах нь эхбичигсудлалын зарчим.
- ⌘ Нэг хүний нэрийг заримдаа хэвтээ, заримдаа босоо -д-гээр бичсэн зүйл бий, жишээ нь: Dasi/dasi, Damba/damba, Delger/delger, Dampil/dampil.
- ⌘ j ийг шилбээр бичсэн
- ⌘ Дэвсгэрлэн орсон –ү ийн өмнө хоёр цэг тавьсан, ж.: , .
- ⌘ Rinćen гэдэг нэрийг Эрдэнэ, Rinćin, Ringćin, Eriñćin гэх зэргээр бичсэн.
- ⌘ Нэг нэрийг хэд хэдэн янзаар бичсэн зүйл нэлээн бий. Түүнийг дураар засч нэг мөр болгоогүй. Уул эхдээ ямар байгаагаар нь хуулах нь зүй. Жишээлбэл,

Lhamuᠰoy/Lhamᠴoy, Damirin/Damiran/Damarin, Idam/Idama/Idam-a, Bayingjur /Bayingjuur, Lombo/Lomboo, ᠰebel/ᠰebil/ᠰibil, ᠰedendorji/ᠰedengdorji гэж хоёр өөр биччихээд, тэр нь нэг айлын хоёр хүүхдийг ялгасан тохиолдол ч бий:

Gongsürünjab(79347-45-621)... o ᠵasay o ᠰedendorji(79347-46-1493)

... o ᠰedengdorji(79347-46-1495).

- ᠰ гүнг-үн гэдэг үгийг гүнг-ни гэж бичсэн: o гүнг-ни ᠵerge ᠵasay o ᠰenggünjab(79347-44-143).o гүнг-ни ᠵerge ᠵasay o Yündünčeweng(79347-45-494), Güngsengbambar(79347-46-1263).
- ᠰ Нэгдүгээр үеэс хойш орсон -ү ийг урт шилбэтэй бичсэнийг том -Ü гээр тэмдэглэв: ᠰenggünjab, Rabjün, BatutÖri.
- ᠰ Хавсармал нэрийн хоёрдугаархи нь эгшгээр эхлэсэн байвал хам бичсэн байна. Үүнийг том үсгээр бичиж ялгаж өглөө: GünggeOdser, BatuItegel [Batu-Itegel], BatuErdeni, EngkeAmur, BaĵarAyusi, ᠰedengIsi, ᠰewengOyidub, ᠰeberErdeni.
- ᠰ “Охин” гэдэг үгийг ökin, oqin гэж хоёр янз бичсэн.
- ᠰ Зарим хэсэг урагдаж алга болсон: 44-р үеийн Чойжамцын 6,7,8,9,10-р хөвүүдийн нэрс, 46-р үеийн 739 дугаарт бүхүй Вамбү-гээс 752 дугаарт бүхүй Amursana хүртэл уул гэрийн үеийн бичмэл бороонд норж, урагдан тасарч үгүй болсон хэсэгтэй. Эдгээр хэсгийг бусад гэрийн үеийн бичмэлүүдтэй тулган үзэж нягтлах, нөхөх шаардлагатай.
- ᠰ Лидер гэсэн нэрийг Lider гэж уншиж болох авач, Йөншөбү Ринчен багш насан өөд болохынхоо өмнөхөн оросоор бичиж, Монголын судлал цувралд хэвлүүлэхээр өгсөн боловч Главлитийн босгыг давж чадаагүй " Сказители и сказочники у монголов " гэдэг алдарт зохиолд “Лидар сэцэн” гэдэг нэр олонтаа гардаг тул, Lidar гэж буулгалаа.
- ᠰ Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэл нь монголчуудын нэр ижилсүүлэхийн нэвтэрхий толь. Хүүхдүүдийнхээ нэрийг ижилсүүлэхдээ үгийн утгаар, үсгээр ба үеэр толгой холбох; сүүл холбох; хавсарсан нэрсийг авиагаар ба утгаар ижилсүүлэх гэх мэт олон янз байдаг. Жишээлбэл, Эрдэнэ / Радна / Ринчин гэх буюу, Darĵiy-a(79347-46-1188)...o Tegüsčoytu(79347-47-2376)
  - ...o Delgerčoytu(79347-47-2377)
  - ...o Bayangčoytu(79347-47-2378)
 Demčüg(79347-46-1237)...o Mabumdorĵi(79347-47-2431)
  - ...o Gengdündorĵi(79347-47-2432)
  - ...o Gombudorĵi(79347-47-2433)
  - ...o Jangčubdorĵi(79347-47-2434)
 ᠰedenĵab(79347-46-1501)...o Langgünĵab(7947-47-2843)
  - ...o Gombuĵab(7947-47-2845)
  - ...o Čoyĵunĵab(7947-47-2846)
  - ...o Lhamuĵab(7947-47-2847)

Нэр ижилсүүлэхдээ ив ижил нэр өгсөн нь цөөнгүй. Монголчууд түүнийгээ их,



бага, дунд хэмээн ялгадаг заншилтай. Энэ нь дээр үеийн уламжлал. жишээ нь:

Senggepil(79347-46-1533)...oĶeden(7947-47-2901)

...oĶeden(7947-47-2902)

Gangjur(79347-46-1560)...oGongĶuyjab(7947-47-2943)

...oGongĶuyjab(7947-47-2945)

Lubsangdorji(79347-47-1722)...oJamsaran(7947-48-3192)

...oJamsaran(7947-48-3193)

Ķerindorji(79347-47-1990)...oJamsarin(79347-48-3546)

...oJamsarin(79347-48-3547)

Нэр ижилсүүлэхдээ зөвхөн хүүхдүүдийнхээ нэрийг хооронд нь ижилсүүлээд зогсохгүй, эцэг хөвүүн хоёр ижил нэртэй байх нь цөөнгүй, жишээлбэл


GombuĶab(79347-47-1692)ийн хөвүүн oĶasaγoGombuĶab(7947-48-3160)

GombuĶab(79347-47-1759)ийн хөвүүн oGombuĶab(7947-48-3254)



GombuĶab(79347-47-1964)ийн хөвүүн oGombuĶab(79347-48-3513)


Dangjin(79347-47-1993)гийн хөвүүн oDanjin(79347-48-3555).

Одоогоор ,зургаан метр гаруй голчтой уул Угийн бичгийг нийтэд нь дэлгэн зураг авах техникийн боломж байхгүй байгаа тул ерөнхий байдал, хэсэгчилсэн, чанар муу зургуудыг толилуулахаас өөр замгүй байна ↓



















































Зөвхөн Монголд 3 ширхэг байгаа гарбичмэл Угийн бичиг





ж Угийн бичигт тухайн хүний нэр, хэддүгээр хөвүүн болох, хэргэм зэргэ, тушаал,нас, бичиг үсэг мэдэх эсэх, хүний зан төлөв, эрүүл мэнд, ял шийтгэл зэргээс гадна, нэрт хутагтуудад шавь оруулсан тухай тусгай тэмдэглэл хүртэл байдаг, жишээлбэл:

- Soyijungjab(79347-46-1492)...oIsiOyidubjamčan(7947-47-2831) [Jibjungdamba qutuytu-du šabi bolʹajajuqi] Wangdanjab(79347-46-1502) Gongčuyjab(7947-47-2852) [egün-i Jibjundamba-du šabi bolʹajajuqi]
- oDorjijab(7947-47-2686)[Düngkür qutuytu-du šabi bolʹajai]. Дүнхэр хутагт гэдэг нь 46-р үеийн Idamjab(79347-46-1420)ын хоёрдугаар хөвүүн Цэдэнжав байна.
  - o düngkür qutuytu oČedenjab(7947-47-2706).
- Говийн догшин Ноён хутагт Данзанрабжаа 1803 оны гахай жил одоогийн Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт төрсөн, нэгэн өдөр өөрийн **өмнөх дүрийг** таньсан гэжгээдэг. Говийн догшин Ноён хутагт Данзанрабжаа бол Ноён хутагтын **хойт дүр**. Өмнөх дүр нь алдартай хутагт байж таарна. Хэн гэдэг хүн байв, эрхбиш бичиг зохиолд гарах учиртай. Судлан буй Угийн бичигт нэгэн Ноён хутагт гарав. Бусад хутагтуудын нэрийг бичсэн атлаа, энэхүү хутагтын нэрийг л хэлсэнгүй, зүгээр л “Ноён хутагт” гэсэн байна. Нэртэй нэргүй, “Ноён хутагт” л гэвэл олноор мэдэх алдартай, Чингисийн алтан ургаас удамтай хутагт байсан байж магадгүй. Бөртчоноос 50-р үе, Чингис Хаанаас 27-р үед гарч байгаа тул мянга долоон зуун хэдэн оны хүн болно. Тэрхүү нэрт “Ноён хутагт”, түүний хүүхдүүдийн уг эхээр жишээлэн, Угийн бичгийг хэрхэн хөтлөдөг, дээш хэрхэн холбодгийг сонирхуулбал:





[51-р үе.10964]    
 [51-р үе.10963]  ⇒ [50-р үе.8646]   ⇒ [49-р үе.6012]  ⇒ [48-р үе.3815]   
 ⇒ [47-р үе.2161]  ⇒ [46-р үе.1062]  ⇒ [45-р үе.387]   
 ⇒ [44-р үе.105]  ⇒ [43-р үе.25]  ⇒ [42-р үе.6]  ⇒ [41-р үе.979]     
 ⇒ [40-р үе.864]   ⇒ [39-р үе.796]   ⇒ [38-р үе.749]  ⇒ [37-р үе.719]   
 ⇒ [36-р үе.712]  ⇒ [35-р үе.706]  ⇒ [34-р үе.695]  ⇒ [33-р үе.685]  ⇒ [32-р үе.668]  ⇒ [31-р үе.654]  ⇒ [30-р үе.618]   ⇒ [29-р үе.573]   
 ⇒ [28-р үе.483]  ⇒ [27-р үе.375]  ⇒ [26-р үе.252]  ⇒ [25-р үе.176]  ⇒ [24-р үе.123]  ⇒ [23-р үе.108]   ⇒ [22-р үе.91]   ⇒ [21-р үе.80]    
 ⇒ [20-р үе.75]  ⇒ [19-р үе.64]  ⇒ [18-р үе.60]   ⇒ [17-р үе.49]  ⇒ [16-р үе.40]  ⇒ [15-р үе.37]   ⇒ [14-р үе.33]     
 ⇒ [13-р үе.29]  ⇒ болно.


ж Гэрийн үеийн бичмэлийг засцагаан үйлдэж, хэвдүүлж хянан нягталахдаа алдаа мэдгийг шууд баллаж сохолж, дээр дээрээс нь дарж бичдэггүй. Шүүдэглэгч, бурууг засахдаа дээр нь цаас наагаад нямбайлан засч бичдэг байсан,Жишээ нь: Taulai гэж бичсэнийг дээр нь цаас наагаад Dayulai(7947-48-3310), Bendege гэж бич-


сэнийг дээр нь цаас наагаад Badai(7947-48-3315) болгосон гэх мэт.

- ✎ Монголоор бичсэнийг сайтар ажиглахгүй бол, ташаа уншиж болохоор нэлээн зүйл байдаг, жишээлбэл, Баяр ба Базар(урт шилбээр бичсэн тохиолдолд), Аюуш ба Аюухи: Ayusi(79347-47-2025)...oAyuki(79347-48-3617) гэх мэт олон.

### 03. Угийн бичиг бичих тусгай төхөөрөмж

Номын санд буй хоёр Угийн бичгийн нэг нь, том зургаан ханат гэрийн буйрын чинээ, “цуувай цагаан”(11981.G-23-23a. T-3184) хэмээх 75 см орчим энтэй даавуун дээр хар бэхээр бичсэн, нөгөөх нь “цуувай цагаан” аасаа зузаахан, “нягт цагаан бөс”(11982.G-23-23a. T-3184) нэртэй даавуун дээр бичсэн. Олон зүйдэлтэй. Дугариг болгохын тул ухдас оруулсан. Оёдол маш нарийн. Гараар оёогүй. Оёдлын машинаар зүйж оёсон. Оёдлын зах 1 см орчим бөгөөд “цаваг  çabuy” буюу “царваг  çarbuy”-т “ээдэн  egedeng” наалдуулж эргүүлэн давхарлаж индэж( ingdekü) хатаасан байна. Эндээс, монгол улсад оёдлын машина хэдийд орж ирсэн, оёдолчин нь хэн байсан гэдэг асуулт аяндаа гарна. Уул Угийн бичгийг үйлдэх үед буюу 1915 онд Монголд оёдлын машина хэдийн орж ирчихсэн байж. Улаанбаатар хотод саяхан болтол “сайван”, “сайвангийн газар” гэж байсан. Тэр нь хятад оёдолчны газрыг хэлдэг. “Сайван” гэдэг нь хятад хэлний 裁缝 cǎi-féng, fèng гэдэг үгийн монголжсон дуудлага.

- ✎ Судлан буй Угийн бичиг маань 6м гаруй голчтой, их бага 16 цагариг зурсан, 14 нь хүний нэртэй. Эндээс, хэдэн мянган хүний нэрийг 6м голчтой тийм том даавуун дээр, ямар байранд, хэд хичнээн хугацаанд, бийрээр хэрхэн бичсэн бэ гэдгийг төсөөлөхөд ч бэрх. Бэлэн юмыг зөвхөн хуулаад бичихэд л бараг жил тойрч байна. Мөн, бүтэн зургийг нь авъя гэхэд л өнөөгийн байшин савны өрөөний эрс ( ersü) намдана; хоёр босоо тэнхлэгт Угийн бичгээ ороож, тэнхлэгээ эргүүлэн зургийг нь авъя гэхэд хамгийн сайн нягтралтай орчин үеийн дөрвөн аппарат үл хөдлөх маягаар зоосон баймаанж боломжтой; дээгүүр нь гүйлгэж зураг авдаг аппарат гэхэд л хэдэн зуун саяын үнэтэй, тэр нь тэгээд хуруу дарам улсад байх жишээтэй. Орчин цагт уугал эхээр нь хуульч гэхэд л ийм бэрхшээлтэй, дэлхийд хосгүй эрднэсийг зуу гаруй жилийн тэртээ монголчууд бүтээж чадчихсан л байна. Үүнийг хийхэд маш нарийн

- тусгай багаж төхөөрөмж шаардлагатай. Тэнгэрийн байдлыг шинжилж, амьсгал, тоо, цаг, мөчийг үзэх, хол ойр, өндөр богиныг хянахуйд хэрэглэх маш нарийн багаж болох “Дүримт сав”( дүримтү сав)ыг бүтээж, ашиглаж чаддаг монголчуудад энэ зэргийн юм юү ч биш байх л даа. Зарим зүйл нь энгийн мөртөө, одоогийн хүмүүсийн толгойд оромгүй тийм боловсронгуй байсныг ч үгүйсгэх учиргүй.
- Хэд хэдэн сар, жил үргэлжлэх учир гадаа байж болохгүй, энгийн гэр байж болохгүй, тэгэхээр эрс өндөртэй дуган маягийн байр байх шаардлагатай.
- Даавуу, тэр мөртөө 6 м гаруй голчтой том даавууг газар дэлгээд, дээр нь суугаад ч юм уу, дөрвөн хөллөөд ч юм уу, бандан ширээнээ хуйлж эвхээд ч юм уу бичих боломжгүй. Зөвхөн нэг тийш чиглэсэн хөдөлгөөн хийхгүй.

Байнга тойруулан эргүүлж, олон сар жил бичиг бичнэ гэдэг аль ч талаасаа боломжгүй. Даавуу атилзаад, үрчилээд, хунираад, сунаад, хөвхөлзөөд байх тул **тусгай төхөөрөмж** шаардлагатай. Угийн бичгийг үзэхэд үсэг, бэх өчүүхэнч тасархайтсан шинж үгүй. Маажиндсан юм уу гэтэл, бичих даавуугаа маажиндаагүй байна. Тиймээс, даавууг сайтар толийлгох, олон мянган нэрийг бийрээр бичихэд зориулсан тусгай төхөөрөмж зохион бүтээх хэрэгтэй болно. Тэр нь : **суурь, иш, хүрдээс** бүрднэ. **Суурь** - үл хөдлөх хүнд, эш ба 6 м гаруй голчтой хүрдээ даахуйц бат бэх байх; **Иш** - бичиг бичих 6 м гаруй голчтой хүрдэн дамрыг даахуйц бөх, үл ганхах, савлах, ойчих аюулгүй байлгах үүрэгтэй. Хүрдэн дамрыг дээш доош хөдөлгөх хоёр арга буй: нэг нь нөгөөдөө багтан, эвхэгдэн богиносож, татахад уртасдаг дуран адил бүтэцтэй. Өндөр намыг тохируулаад чагтлан тогтооно. Нөгөө нь, хоёроос гурван өвдөг буюу үетэй, түүгээрээ нугарч, өндөр намыг зохицуулна. Мөн, оньсон түгжээтэй байна. **Хүрд** – ишнээс урагш хэдийдсэн (ᠬᠦᠷᠳᠦ ketüйд-kü) хөндөл дээр хүрд байрлана. Хөндлийн үзүүр, хүрдний уулзвар булаар эргэж тойрох хөдөлгөөн хийнэ. Хүрд нь, юм бичих 6 м голчтой даавууг тогтоон, толигор байлгах зориулалттай. Бичих талбай 6 м тул, хүрд голчоороо тэрнээс нэлээд том байна. Хүрд нь төвшин ба гулдаар, мөн, 360 хэм тойрч эргэдэг байна. Тэгэхгүй бол, тойрмол Угийн бичгийг бичих боломжгүй. Хүрдийг хүнд модоор зангидах албагүй. Хулс мэт хөнгөн зүйлээр дугариглан хийж болно. Хүрдний эргэхийг зогсоох чагт, оньсон түгжээ байна. Оньсыг татваас хүрд гарын аяар тойрон улирах (ᠤᠯᠠᠷᠢᠬᠤ ulariqu) ба оньсыг түлхвээс түгжигдэн, хүрд үл хөдлөнө. 6 м гаруй голчтой хүрдийг ширлэж хэнгэрэг мэт болгох бэрх. Тийм өргөн энтэй шир олдохгүй. Шир залгаж хүндрүүлснээс, даавуу залгаж хийгээд маажиндах (ᠮᠠᠵᠢᠩᠳᠠᠬᠤ majingdaq) эсвэл, цардваас (ᠴᠠᠷᠳᠠᠬᠤ čardaqu) амар. Энэ нь үрчлээсгүй, хөвхөлзөхгүй, толигор даавуу суурь болох ба угаар нь гархидна (ᠶᠠᠷᠠᠴᠠᠳᠠᠬᠤ yaraqadaqu = бүслүүрдэнэ). Дээрээс нь бичиг бичих даавуугаа углаж, толийлгон чанга гархидна. Ийнхүү бичиг бичих төхөөрөмж ба талбай бэлэн болно. Зайлшгүй хэрэгцээт тусгай **төхөөрөмжийн** байдлыг төсөөлөн үзүүлбэл ↓



өндөр ≈ 7 м.

✪ Хүрд, нугаст иш, суурь



Эвхмэл байдал

↘ Дугуй хүрд



Дугуй хүрдний эргэх(360 хэм) байдал.  
Налууг тохируулна.

Шалнаас дээш,  
хүрдэн дугуй хүртэл  $\approx 1,5$  м зайтай байвал  
зохимжтой.

- Уул Угийн бичиг 16 цагаригтай. 50-300 см хэгээс(keges, радиус)тэй тойрог буюу цагариг татахад тусгай гортиг (гортиг үөртү) хэрэгтэй. Цагариг зурсныг үзэхэд, будаг тасалдсан, нүүсэн, зуувайсан, үелсэн, эрчилсэн, өргөн нарийн болсон зүйл үгүй байна. Тэгэхээр угсаар тойрог татаадүй байна. Мөн, Угийн бичгүүдийн голд гортигийн өрөөсөн гуя(хөл)ны шовх үзүүр шигдсэн нүх, цүлхийж хонхойсон ул мөр алга. Арванзургаан удаа цагариг зурахад даавууны голд эрхбиш нүх юм уу цүлхийж хонхойсон ул мөр гарах учиртай. Энэ нь, янз бүрийн тохируулгатай, хатуу биет гортигийг тусад нь бэлдсэн гэсэн үг. Тэгээд, хүрд ба гортигийг эсрэгцүүлэн босгож тавиад гортигоо биш, хүрдээ эргүүлж цагаригаа зурсан төлөв харагдана. Эхлээд бүх цагаригаа зурсан бус, тооно цагаригаа 50 см хэгээстэй зурж дотор нь “Сэцэн хан Шолой” гэж бичээд, тооно цагаригтаа тулган бинт тавьж, хүүхдийн нэрсийг зүүн гараас баруун гар тийш цагариглан өрж биччихээд, хэний хүүхэд болохыг харуулсан холбоосоо зураас юм уу цэгээр хийчихээд, дараа нь хоёрдахь цагаригаа зураад, мөн нэрсээ бичээд, холбоосоо хийчихээд, хамгийн урт нэрийнхээ араар дараагийн цагаригаа зураад явсан нарийн дэс дараатай байна. Энэ нь, цагариг ямар ч урт нэрийн сүүл дээгүүр дарж гараагүй, цагариг хоорондын зай ижил бус байгаагаас илт байна. Эхлээд цагаригаа зурчихвал, ямар хэмжээний урт нэр гарах, тэр нь нэгэнт зурсан цагаригт багтах эсэх нь эргэлзээтэй болно. Ямартай ч, цагариг дамнасан нэр байхгүй. Харин түрүү цагаригт гарсан хүний хүүхдийг залгасан зураасан ба цэгэн холбоос, магадгүй, хэдэн арван см үргэлжлэн дараачийн цагаригт гарах тул бичих бичээс, хуулах хүнийг ёстой шар махтай нь хатаана даа. Хоорондоо мм зайтай, тэр урт зураасыг алдахгүй дагана гэдэг алдаа гарахад хялбар, нүдэнд нэн халтай ажил. Гэвч яалтай нь билээ. Өвгөд дээдэс маань бидэндээ үлдээсэн нандин өв тул зүтгэхээс аргагүй байв. Алдаж эндсэн зүйл байх аваас хүлцэл өчсү:

Цагариг	Хэгээс(радиус)ийн урт
тооно цагариг	50 см
хоёрдугаар цагариг	$\approx 70$ см. 1,2-р цагариг хоорондын зай $\approx 20$ см
гутгаар цагариг	$\approx 90$ см. 2,3-р цагариг хоорондын зай $\approx 20$ см
дөтгөөр цагариг	$\approx 107$ см. 3,4-р цагариг хоорондын зай $\approx 17$ см
тавдугаар цагариг	$\approx 124$ см. 4,5-р цагариг хоорондын зай $\approx 17$ см

зургадугаар цагариг	≈149 см. 5,6-р цагариг хоорондын зай ≈25 см
долдугаар цагариг	≈174 см. 6,7-р цагариг хоорондын зай ≈25 см
наймдугаар цагариг	≈204 см. 7,8-р цагариг хоорондын зай ≈27 см
есдүгээр цагариг	≈225 см. 8,9-р цагариг хоорондын зай ≈24 см
аравдугаар цагариг	≈240 см. 9,10-р цагариг хоорондын зай ≈15 см
арваннэгдүгээр цагариг	≈250 см. 10,11-р цагариг хоорондын зай ≈10 см
арванхоёрдугаар цагариг	≈257 см. 11,12-р цагариг хоорондын зай ≈7 см
арвангуравдугаар цагариг	≈265 см. 12,13-р цагариг хоорондын зай ≈8 см
арвандөрөвдүгээр цагариг	≈271 см. 13,14-р цагариг хоорондын зай ≈6 см
арвантавдугаар цагариг	≈277 см. 14,15-р цагариг хоорондын зай ≈6 см
арванзургадугаар цагариг	≈283 см. 15,16-р цагариг хоорондын зай ≈6 см

байна.